

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/32/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Ц.Гантулга Утас: 70432545 цахим хаяг: gantulga.ts @audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	11
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
4.1 Залруулсан алдаа.....	12
4.2 Зөвлөмж .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433081  
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.21 № 252  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Б.ГОМБОСҮРЭН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ҮСӨЛДБААТАР

001020123

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>33,365,793.05</u></b>	<b><u>40,465,012.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	20,448,645.05	25,790,928.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	245,950.00	300,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	19,648,821.00	25,490,928.00
3351	Байгууллагаас авах авлага	6,430,000.00	100,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	13,218,821.00	25,390,928.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	12,917,148.00	14,674,084.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	477,949.00	477,949.00
35110	Тусгай зориулалттай материал	477,949.00	477,949.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	12,439,199.00	14,196,135.00
35410	Бичиг хэргийн материал	2,574,344.00	3,061,880.00
35420	Аж ахуйн материал	8,478,355.00	9,747,755.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,386,500.00	1,386,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>306,738,450.90</u></b>	<b><u>301,521,492.37</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	306,738,450.90	301,521,492.37
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	299,538,450.90	294,321,492.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	294,612,490.00	294,612,490.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-10,665,285.52	-16,667,526.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,145,526.00	154,945,526.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-138,964,239.09	-142,406,776.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,634,399.30	9,634,399.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,145,400.93	-9,428,939.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,609,630.00	4,609,630.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-688,668.86	-977,310.86
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,200,000.00	7,200,000.00
39301	Программ хангамж	772,500.00	772,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-772,500.00	-772,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,200,000.00	7,200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>340,104,243.95</u></b>	<b><u>341,986,504.37</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>339,821,454.63</u></b>	<b><u>341,986,504.37</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	339,821,454.63	341,986,504.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	254,315,896.00	254,315,896.00
51101	Өмч: - төрийн	254,315,896.00	254,315,896.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-23,223,749.95	-21,058,700.21
51210	Өмнөх үеийн үр дүн	-23,223,749.95	-23,675,601.95
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,616,901.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,729,308.58	108,729,308.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>340,104,243.95</u></b>	<b><u>341,986,504.37</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>256,010,296.00</b>	<b>267,287,409.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>69,695,296.00</b>	<b>46,630,160.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	69,695,296.00	46,630,160.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	69,065,296.00	46,630,160.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,231,296.00	45,967,660.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	834,000.00	662,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>186,315,000.00</b>	<b>220,657,249.08</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	186,315,000.00	220,657,249.08
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	186,315,000.00	220,657,249.08
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>251,710,751.92</b>	<b>264,670,507.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>251,710,751.92</b>	<b>264,670,507.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	227,446,423.87	227,510,950.34
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	146,152,305.61	129,777,917.00
210101	Үндсэн цалин	146,152,305.61	129,777,917.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,945,370.26	16,609,682.90
210201	Тэтгэврийн даатгал	12,424,079.00	11,687,329.90
210202	Тэтгэмжийн даатгал	1,461,656.00	1,297,779.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,169,326.00	1,038,222.00
210204	Ажилгүйдлийн даатгал	262,755.27	235,123.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,627,553.99	2,351,229.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,929,768.00	20,762,893.30
210301	Гэрэл, цахилгаан	16,907,968.00	15,160,573.30
210302	Түлш, халаалт	3,300,000.00	3,260,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,721,800.00	2,342,320.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,315,343.00	10,688,079.61
210401	Бичиг хэрэг	3,802,105.00	1,917,364.00
210402	Тээвэр, шатахуун	6,731,500.00	4,852,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,493,738.00	2,303,615.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	258,000.00	206,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,409,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,302,350.00	1,659,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	250,000.00	1,659,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,192,000.00	25,200,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	25,200,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,832,000.00	7,648,500.00
210702	Дотоод албан томилолт	8,832,000.00	7,648,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,141,380.00	2,322,232.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	220,000.00	176,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	17,380.00	43,332.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,300,000.00	1,802,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,635,907.00</b>	<b>12,842,645.53</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	936,000.00	1,886,687.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,450,000.00	939,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,249,907.00	10,016,958.53
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,264,328.05</b>	<b>37,159,557.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,655,300.00</b>	<b>37,159,557.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,085,300.00	36,719,557.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	570,000.00	440,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>4,299,544.08</u></b>	<b><u>2,616,901.74</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>4,299,544.08</u></b>	<b><u>2,616,901.74</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,315,896.00	108,729,308.58	-35,177,886.94	327,867,317.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,648,471.91	1,648,471.91
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>254,315,896.00</b>	<b>108,729,308.58</b>	<b>-33,529,415.03</b>	329,515,789.55
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,299,544.08	4,299,544.08
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>254,315,896.00</b>	<b>108,729,308.58</b>	<b>-23,223,749.95</b>	339,821,454.63
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>254,315,896.00</b>	<b>108,729,308.58</b>	<b>-23,223,749.95</b>	339,821,454.63
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-451,852.00	-451,852.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>254,315,896.00</b>	<b>108,729,308.58</b>	<b>-23,675,601.95</b>	339,369,602.63
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,616,901.74	2,616,901.74

D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,315,896.00	108,729,308.58	-21,058,700.21	341,986,504.37
-----	---------------------------------------	----------------	----------------	----------------	----------------

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>255,977,246.00</b>	<b>267,200,859.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>69,032,246.00</b>	<b>46,543,610.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	69,032,246.00	46,543,610.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	69,032,246.00	45,913,610.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,032,246.00	45,913,610.00
120009	Бусад орлого	00.00	630,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>186,945,000.00</b>	<b>220,657,249.08</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	186,315,000.00	220,657,249.08
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	186,315,000.00	220,657,249.08
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>255,977,246.00</b>	<b>267,200,859.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>255,977,246.00</b>	<b>267,200,859.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>231,682,917.95</b>	<b>230,041,302.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	145,777,999.93	140,856,076.25
210101	Үндсэн цалин	102,585,786.45	107,847,323.35
210102	Нэмэгдэл	38,645,613.48	29,459,152.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,546,600.00	3,549,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	18,837,540.02	17,687,860.92
210201	Тэтгэврийн даатгал	13,006,340.02	12,409,390.41
210202	Тэтгэмжийн даатгал	1,457,800.00	1,326,633.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,166,200.00	1,061,306.57
210204	Ажилгүйдлийн даатгал	291,600.00	262,775.78
210205	Эрүүл мэндийн даатгал	2,915,600.00	2,627,754.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,929,768.00	20,762,893.30
210301	Гэрэл, цахилгаан	16,907,968.00	15,160,573.30
210302	Түлш, халаалт	3,300,000.00	3,260,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,721,800.00	2,342,320.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,057,963.00	9,038,519.61
210401	Бичиг хэрэг	1,799,963.00	1,484,976.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	4,088,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,999,543.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	258,000.00	206,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,260,000.00

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,000,000.00	1,660,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,000.00	1,660,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,800,000.00	24,300,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	4,800,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	19,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,988,000.00	7,648,500.00
210702	Дотоод албан томилолт	8,988,000.00	7,648,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,292,380.00	3,268,332.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	220,000.00	176,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	640,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	425,000.00
210807	Газрын төлбөр	17,380.00	43,332.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,200,000.00	1,860,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,999,267.00	4,819,120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,999,267.00	3,179,420.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,639,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,294,328.05</b>	<b>37,159,557.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	18,685,300.00	37,159,557.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,085,300.00	36,719,557.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	440,000.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	269,774,100.00	266,570,859.08
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	269,774,100.00	266,570,859.08
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	232,614,500.00	229,411,302.08
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	142,082,500.00	140,856,076.25
210101	Үндсэн цалин	108,745,700.00	107,847,323.35
210102	Нэмэгдэл	29,525,300.00	29,459,152.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,811,500.00	3,549,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,102,500.00	17,687,860.92
210201	Тэтгэврийн даатгал	13,733,100.00	12,409,390.41
210202	Тэтгэмжийн даатгал	1,342,300.00	1,326,633.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,073,900.00	1,061,306.57
210204	Ажилгүйдлийн даатгал	268,500.00	262,775.78
210205	Эрүүл мэндийн даатгал	2,684,700.00	2,627,754.96

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,275,100.00	20,762,893.30
210301	Гэрэл, цахилгаан	15,615,600.00	15,160,573.30
210302	Түлш, халаалт	3,300,000.00	3,260,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,359,500.00	2,342,320.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,039,400.00	9,038,519.61
210401	Бичиг хэрэг	1,485,000.00	1,484,976.00
210402	Тээвэр, шатахуун	4,088,000.00	4,088,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,999,543.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	206,400.00	206,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,260,000.00	1,260,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,660,000.00	1,660,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,660,000.00	1,660,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,300,000.00	24,300,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,800,000.00	4,800,000.00
210604	Урсгал засвар	19,500,000.00	19,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,650,000.00	7,648,500.00
210702	Дотоод албан томилолт	7,650,000.00	7,648,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,315,000.00	3,268,332.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	176,000.00	176,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	640,000.00	640,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	425,000.00	425,000.00
210807	Газрын төлбөр	50,000.00	43,332.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,860,000.00	1,860,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4190000.00	4189120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,550,000.00	2,549,420.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,640,000.00	1,639,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	37159600.00	37159557.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	37,159,600.00	37,159,557.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,719,600.00	36,719,557.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	440,000.00	440,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	269,774,100.00	266,570,859.08
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	229,774,100.00	220,657,249.08
131001	Улсын төсвөөс санхүүжих	229,774,100.00	220,657,249.08
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	40,000,000.00	220,657,249.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000,000.00	45,913,610.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	13	13
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл / төгрөгөөр /
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>630,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>630,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	630,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	630000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	630,000.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шатахууны зарцуулалттай холбоотой асуудал дансны хуулийн хэрэгжилттэй зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2022 оны 02 дүгээр сарын 14-наас 2022 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25 -ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Стандартчилал, тохирлын үнэлгээ, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, сорьцын хяналтын ажлын хүрээг өргөжүүлэх, боловсон хүчний чадавхыг сайжруулах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлжээ.

Тус хэлтэс нь Монгол улсын “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай”, “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” хуулиуд болон түүнтэй нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол шийдвэр, дүрэм журмын хүрээнд бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, хэмжих хэрэгслийг баталгаажуулах ажлыг өөрийн итгэмжлэгдсэн хэмжилзүйн 5 төрлийн лабораториудад түшиглэн хэрэгжүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 тоот “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Стандарт хэмжил зүйн газрын дотоод аудит 2021 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 276.4 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 2.7 сая төгрөг төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.8 сая төгрөгөөр буюу 0.99 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд авлага 20.4 сая төгрөг, тайлант онд авлага 25.8 сая төгрөг болж 5.3 сая төгрөг авлага нэмэгдсэн байна. Энэ авлага нь шүүхийн шийдвэрээр 12.6 сая төгрөг нэмэгдэж, бусад байгууллагаас 6.3 сая, ажилчидтай холбоотой 0.5 сая, шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон 0.4 сая төгрөгөөр буурсан холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12.9 сая төгрөг байснаас тайлант хугацаанд тусгай зориулалттай материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатахуун тослох материал, хүнсний материал, бусад хангамжийн материалуудыг 16.8 сая төгрөгөөр худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 0.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 15.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 14.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 466.9 сая төгрөг, тайлант онд машин тоног төхөөрөмж 4.8 сая төгрөгөөр худалдаж авч 170.2 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноор жилийн эцэст 301.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 339.8 сая төгрөг байсан ба оны эцэст 341.9 сая төгрөг болж үр дүнтэй холбоотойгоор 2.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү (-0.4) сая төгрөгийн бичилт хийдсэн байна. Энэ нь Б.Эрдэнэцэцэгтэй холбогдох авлага шүүхийн шийдвэрээр буурч ирсэнтэй холбоотой ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл (-21.0) сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг оны эхэнд үндсэн үйл ажиллагааны зардалд 248.4 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардалд 29.0 сая төгрөг нийт 277,4 сая төгрөгөөр батлуулсны дараа 5, 10 дугаар сарын төсвийн тодотголоор нийт урсгал засварын зардлаас 21,9 сая төгрөг танаж, төрийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 8,2 сая төгрөг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шүүгчийн захирамжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 12.6 сая төгрөг нэмэгдүүлж, нийт 267.2 сая төгрөгөөр сая төгрөг төсөвлөгдсөн байна. Улсын төсвөөс санхүүжих санхүүжилтээс 9,1 сая төгрөгийг дутуу авсан.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 277.4 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд улсын төсвөөс 237.7 сая төгрөг, өөрийн орлогоор 40.0 сая төгрөг, нийт 277.4 сая төгрөг зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 220.6 сая төгрөг, өөрийн орлогоос санхүүжих санхүүжилтээр 45.9 сая төгрөг нийт 266.5 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтэрсэн хэмнэсэн зардал байхгүй байна

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт данснаас 2019 оны татуулсан 06 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 150 мэдээллийг хугацаандаа оруулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий тэтгэвэрт гарахдаа холбоотой 36.7 сая төгрөг, шүүхийн шийдвэрийн дагуу 11.3 сая төгрөг, “Ховдын Хаш-Өргөө” ХХК-ний хийсэн гэрээний дагуу гүйцэтгэсэн ажил үйлчилгээ засварын хөлс 19.5 сая төгрөгийн 4 ажил гүйлгээтэй холбоотой 67.5 сая мэдээллийг байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвөөс зардлын зүйл хооронд шилжүүлэн зарцуулсан 5,700.0 мянган төгрөг зардлыг эдийн засгийн ангиллаар илэрхийлж, тооцооллын зөрүүгээс ажилчидтай холбогдсон авлага 553,8 мянган төгрөг, ажилчидтай холбогдсон өглөг 282.8 мянган төгрөгийн барагдуулж ажилласан байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авлага барагдуулалтыг анхаарах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28,466.6 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 15,020.9 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 13445.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 1 мөнгөн гүйлгээний мэдээллийг хугацаа хоцруулж мэдээлснийг аудитын явцад залруулав.

### 4.2 Төлбөрийн акт

4.2.1. Б.Эрдэнэцэцэг нь Ховд аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэж байх хугацаандаа үйлчлэгч, сахиулаар ажиллаж байсан Х.Тогтбаярыг ажлаас нь чөлөөлсөн байна. Х.Тогтбаяр нь уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй хууль хяналтын байгууллагад хандсанаар, шүүх хэлтсийн даргын ажлаас чөлөөлсөн тушаал нь хууль зүйд нийцээгүй эрх зүйн акт гаргаж Х.Тогтбаярыг буруу халсан тул ажилд нь эгүүлэн тогтоо гэсэн 3 шатны шүүхийн шийдвэр хүчинтэй болж

Х.Тогтбаярын 2019 оны 04 дүгээр сарын 01-нээс 2020 оны 12 дугаар сарын 15 хүртэлх хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэл, шүүхэд гомдол гаргасантай холбогдох бусад зардал нийт 15020929.00 төгрөгийг Стандарт хэмжил хэмжил зүйн хэлтсээс гаргуулахаар захирамж гаргаж түүнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэлдүүлсэн байна.

Энэ нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2-т “Төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл/эс үйлдэх/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн **этгээд** буюу төр хариуцан арилгана, энэ хуулийн 498.5-т энэ хуулийн 498.2-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд боломжгүй үйлдлээр гэм учруулсан бол гэм хориг арилгасан байгууллага өөр учирсан хохирлыг тухай гэм буруутай этгээдээс гаргуулахыг шаардах эрхтэй..., “төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д” төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай этгээдээр нөхөн төлүүлэн гэж заасныг тус тус зөрчиж төсөвт хохирол учруулсан байна гэж үзлээ.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### 4.3 Зөвлөмж

1.Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1.1 **Хөрөнгийн ашиглалттай холбоотой асуудал.**

1.1 Илрүүлэлт: Дансанд бүртгэлтэй байгаа 36 нэр төрлийн 62 ширхэг 13445.7 мянган төгрөгийн хөрөнгө цаашид ашиглагдах боломжгүй байгааг байгууллагын өмч хамгаалах комиссын зүгээс ажил зохион байгуулж арга хэмжээ авалгүй олон жил тайланд тусгагдан өдий хүрсэн нь *Төсвийн тухай 7 дугаар зүйлийн 37.1.7-д “Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх,тайлагнах”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх,...тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” хуулийн заалт, “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн тооллогыг чанартай хийж дахин үнэлэх, актлах хөрөнгийн жагсаалтыг гаргаж дээрх хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд шийдвэрлүүлж цэгцлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	2	28,466.6			1	15,020.9			1	13,445.7

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР